



АРХИВЫН ЕРӨНХИЙ
ГАЗАР



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ
МУЗЕЙ



ШУА-ЛЯН ТҮҮХ
АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН



"САЙН НОЁН ХААН"
САН

**Монгол Улсын төрийн нэрт зүтгэлтэн,
анхны Ерөнхий сайд Түмэнхэн номун эзэн,
Утгэмжит эетэй, Эрх дайчин Сайн ноён хан
Т.Намнансүрэнгийн мэлхий гийсний 140
жилийн ойг зориулсан**



**"Монгол Улсын анхны
Ерөнхий сайд, Сайн ноён хан
Боржигин
Төгс-Очирын Намнансүрэн-140"
ҮЗЭСГЭЛЭН**

Улаанбаатар
2018



МЭНДЧИЛГЭЭ ҮГ

Бидний монголчууд өнө эртний түүх, соёлтой, өндөр төр, өнөр ардаа хамгаалан тэмцэх баатар эрс, цөс ихт зоригтнуудын орон билээ.

1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгалын үр дүнд сэргээн байгуулагдсан Монгол Улсын тусгаар тогтнолыг бататган хамгаалах, олон улсаар хүлээн зөвшөөрүүлэхийн төлөө тэмцэлд жинтэй хувь нэмэр оруулсан түүхэн зүтгэлтнүүд цөөнгүй бий. Тэдний нэг нь XX зууны Монголын төрийн нэрт зүтгэлтэн, дипломатч, анхны Ерөнхий сайд Түмэнхэн номун эзэн, Итгэмжит эгтэй, Эрх дайчин Сайн ноён хан Боржигин овогт Төгс-Очирын Намнансүрэн юм.

Халхын Сайн ноён хан Т.Намнансүрэн нь 1878 онд Сайн ноён аймгийн Сайн ноёны хошуу буюу одоогийн Өвөрхангай аймгийн Уянга сумын нутагт мэндэлжээ.

Сайн ноён хан Т.Намнансүрэн нь 1884 онд бэйс Чимэддоной, түшмэл Шийлэг нарт шавь орж, монгол, манж бичиг үсэг заалгац оюуны амсар нээгдэж, 1897-1908 онд Сайн ноён аймгийн цэргийг захирах туслагч жанжины хэбэй, 1906-1912 онд Сайн ноён хан аймгийн Цэцэрлэгийн чуулганы дарга, 1912-1915 онд Шадар сайд, Дотоодын зэрэг олон яамны хамаг хэргийг бүгд ерөнхийлөн захирах яамны тэргүүн сайд, 1915-1919 онд Шадар сайд, Ерөнхийлөн шийтгэх сайд, Цэргийн яамны тэргүүн сайд мөн 1914-1919 онд Улсын Дээд хурлын даргын албан тушаалд хавсран ажиллаж байсан Монгол төрийн тулхтай зүтгэлтэн байлаа.

Сайн ноён хан Т.Намнансүрэн нь шинэ Монгол Улсын гадаад улстай байгуулсан анхны гэрээ болох 1912 оны Орос-Монголын найрамдлын гэрээ, хавсарган тогтоосон гэрээ бичгийг байгуулахад Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчдийн тэргүүнээр ажиллаж, 1913-1914 онд Хаант Орос улсад Монгол Улсын төрийн тэргүүний анхны айлчлал хийснээр хорьдугаар зууны Монгол Улсын гадаад харилцааны үндсийг тавьсан юм.

Сайн ноён хан Т.Намнансүрэн нь хүн төрөлхтөний хөгжлийн чиг хандлагыг зөвөөр ухаарч, Монгол Улсад парламентын үр хөврөл болсон Улсын Дээд, доод хурлыг байгуулах, хууль цаазын шинэтгэл хийх, газар тариаланг хөгжүүлэн, эдийн засгийг дэгжүүлэх зэрэг шинэтгэлийн олон саналыг дэвшүүлж, дангаараа болон бусад сайдуудтай нэр хамтлан Богд хаантанд айлтгал өргөн, зарлиг буулгуулан хэрэгжүүлж байсан нийгмийн хөгжил дэвшлийн төлөө тууштай тэмцэгч, шинэтгэгч хүн байлаа.

Энэ жил Монгол Улсын анхны Ерөнхий сайд Түмэнхэн номун эзэн, Итгэмжит эгтэй, Эрх дайчин Сайн ноён хан Боржигин овогт Т.Намнансүрэнгийн мэлмий гийсний 140 жилийн ой тохиож байна.

Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Архивын ерөнхий газар, ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн, Монголын Үндэсний музей болон “Сайн ноён хаан” сан хамтран “Монгол Улсын анхны Ерөнхий сайд, Сайн ноён хан Төгс-Очирын Намнансүрэн-140” сэдэвт архивын баримт бичиг, гэрэл зураг, кино зураг, эд өлгийн үзэсгэлэнт хамтран зохион байгуулж байна.

Тус үзэсгэлэнд, Сайн ноён хан аймгийн ноёд, тайж нарын гэрийн үеийн бичмэл, Сайн ноён ханы хошууны нутгийн зураг, Сайн ноён хан Т.Намнансүрэнг төрийн албанд томилсон, чөлөөлсөн, шагнасан зарлигууд, Богд хаантанд айлтгасан айлтгал, буулгасан зарлиг, Хаант Орос улсад айлчилсан айлчлал, Сайн ноён хан Т.Намнансүрэнгийн гэр бүл, төрөл төрөгсдөд холбогдох олон сонирхолтой ховор баримт бичиг, гэрэл зураг болон кино зургийг дэлгэн толилуулж байна.

Мөн Монголын Үндэсний музейн сан хөмрөгөөс Монгол Улсын анхны Ерөнхий сайд, Сайн ноён хан Т.Намнансүрэнгийн эдэлж хэрэглэж байсан дөрвөн бадамтай, дөрвөн хөлтэй тулга, Хаант Орос улсаас Монгол Улсын Бүгд ерөнхийлөн захирах сайд, Бүрэн эрх барих Элчин сайд, Сайн ноён хан Т.Намнансүрэнд дурсгасан мөнгөн хайрцаг зэрэг биет ховор үзмэрүүдийг тавьсан нь та бүхний сонирхолыг татна гэдэгт найдаж байна.

Та бүхэн бидний бэлтгэсэн үзэсгэлэнг таалан болгооно уу.

Архивын ерөнхий газрын даргын
үүргийг түр орлон гүйцэтгэгч

С.Энхбаатар

Үзэсгэлэн: 2018.12.10-12.16-ны өдрүүдэд Монголын Үндэсний музейн үзэсгэлэнгийн танхимд
2018.12.25-ны өдрөөс Архивын ерөнхий газрын үзэсгэлэнгийн танхимд ажиллана.




Сайн ноён засаг хошой чин ван
Т.Намансүрэн



1772.02.19

- Сайн ноёны аймгийн нутгийн дөрвөн хэцийг тогтоон бичиж өргөсөн дэвтэр данс


МУУТА. ТБА, ХН-58, Д-1, ХН-1



1780. 11.05

- Сайн ноён засаг чин ван Норовжавын өргөмжлөл


МУУТА. ТБА, ХМ-168, Д-2, ХН-915



1779 он

- Зарлигаар тогтоосон Гадаад Монгол, Хотон аймгийн ван, гүнгүүдийн илтгэл шаштирын аравдугаар дэвтэр. Халхын Сайн ноён аймаг


МУУТА. ТБА, ХМ-168, Д-3, ХН-5



1919.11.04

- Түмэнхэн номун эзэн Сайн ноён хан Батсүхийн уг эх

МУУТА. ТБА, ХА-59, Д-1, ХН-29, Б.8



1912.02.12

- VIII Богд Жибзундамба хутагт болон Халхын Түшээт хан Дашням, Сэцэн хан Навааннэрэн, Засагт хан Содномравдан, Сайн ноён Намнансүрэн нараас Хаант Орос улсын эзэн хаанд тусламж хүсэж бичсэн 21 зүйлт бичиг

МУУТА. ТБА, ХА-4, Д-1, ХН-25 Х.1-14



1911.12.29

- VIII Богд Жибзундамба хутагт Монгол Улсын хаан ширээнд өргөмжлөгдөөд буулгасан хишиг тархах зарлиг

МУУТА. ТБА, ХА-6, Д-1, ХН-513, Б.4




- Монгол Улсын төрийн шар ордны хэсэг /XX зууны эх/



1911.12.02

- Засагт хан, Сайн ноён аймгийн ноёдод Улиастайг чөлөөлөхийг тушаан илгээсэн бичиг

МУУТА. ТБА, ХА-2, Д-1, ХН-1, Б.8



1911.12.14

- Засагт хан, Сайн ноён аймгийн цэрэгт олгох зэвсэг зүйлийг Хиагтын баруун этгээд харуулаар замнан тээлгэж, ойр нутагтай хошуу тамгын газраа хурдан хүргүүлж, хүлээлгэх зэрэг учир харьяат харуулыг бүгд захирах бэйс Сандагдоржид тушаах бичгийн эх


МУУТА. ТБА, ХА-2, ХН-67, Б.1



1911.12.12

- VIII Богд Жибзундамба хутагтаас баруун хоёр аймгийн цэргийг дайчлан хуралдуулж, газар орныг ариун чанга болгон сэргийлүүлэхээр тушаасныг гүйцэтгэн дагаж, шийтгүүлэх зэрэг учир баруун хоёр аймгийн Да, жанжин нарт явуулах бичгийн эх.

МУУТА. ТБА, ХА-2 ХН-76, Б.1




1919.11.27

- Түшмэл Тогтохыг шагнах тухай бичигт, Сайн ноён Т.Намнансүрэн Улиастайг чөлөөлөх хэргийг нууцаар удирдан, зохион байгуулж байсан тухай тэмдэглэсэн нь


МУУТА. ТБА, ХА-7, Д-1, ХН-488, Б.52



Бүгд ерөнхийлөн захирах яамны тэргүүн сайд Т.Намнансүрэн




- Бүгд ерөнхийлөн захирах яамны тэргүүн сайд Т.Намнансүрэнгийн хэвлэмэл хуудас
- Сайн ноён хан Т.Намнансүрэнгийн “Далха” бурхантай сахиус



1912.07.12

- Шадар сайд, Сайн ноён ханыг Зарлигаар олон яамны Бүгд ерөнхийлөн захирах сайд талбисан явдлыг мөнхүү сайд ханы зэрэг арван зургаан газраа явуулан тушаах бичгийн эх


МУУТА. ТБА. ХА-3, Д-1, ХН-328, Б.17



1913.08.28

- Бүгд ерөнхийлөн захирах яамнаас харьяат олон яамны эрхлэн шийтгэх хэрэг зүйлийг ялган салгаж айлтгаад, зарлиг ёсоор болгосныг хичээнгүйлэн дагаж шийтгүүлэхээр ирсэн хэрэг

МУУТА. ТБА. ХА-3, Д-1, ХН-413, Б.4



1912.11.02

- Монгол-Оросын найрамдлын гэрээ, хавсарган тогтоосон гэрээ



Гадаад харилцааны төв архив



1912.11.02

- Монгол-Оросын найрамдлын гэрээнд Монгол, Орос улсын Засгийн газрыг төлөөлөн оролцогчид

МУУТА. КГЗДАБА



1913.02.16

- Монгол-Оросын Засгийн газрын хооронд байгуулсан Монголын цэргийг бэлтгэн сургах гэрээ

МУУТА. ТБА. ХА-3, Д-1, ХН-476, Б.1

1914.03.24

- Бүгд ерөнхийлөн захирах яамны сайд Т.Намнансүрэн нараас тариаланг хөгжүүлэн, эдийн засгийг дэгжүүлэх талаар айлтгасан айлтгал, буулгасан зарлиг

МУУТА. ТБА. ХА-173, Д.1, Б.130



1913 он

- Сайн ноён хан Т.Намнансүрэн Хаант Орос улсад хийсэн айлчлалын үед



1913-1914 он



- Бүгд ерөнхийлөн захирах сайд Сайн ноён хан Т.Намнансүрэнгийн нэрийн хуудас

МУУТА. ТБА. Х-580, Д-1, ХН-113, Б.10

1913 он

- Монгол Улсын Ерөнхий сайдын айлчлалын бүрэлдэхүүнд багтсан төлөөлөгчид Оросын төмөр замын буудал дээр

ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн



1913-1914 он

- Шадар сайд, Бүгд ерөнхийлөн захирах яамны тэргүүн сайд, Сайн ноён хан Т.Намнансүрэн зарлигаар Орос улсад зарагдахад аливаа хэрэг зүйлийг өдөр дараалан тэмдэглэсэн данс

МУУТА. ТБА. ХА-2, Д-1, ХН-10

1913-1914 он.

- Бүгд ерөнхийлөн захирах сайд, Сайн ноён хан Т.Намнансүрэн зарлигийг дагаж Орос улсад одохуйд олон улсад явуулсан бичгийг сийрүүлэн тэмдэглэсэн данс

МУУТА. ТБА. ХА-4, Д-1, ХН-18



1913 он

- Хаант Орос улсад айлчилсан Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчид ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн




1913 он

- Сайн ноён хан Т.Намнансүрэн Хаант Орос улсын төлөөлөгчидтэй хийсэн уулзалтын үеэр ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн



1913 он

- Монгол Улсын Ерөнхий сайд, Сайн ноён хан Т.Намнансүрэн тэргүүтэй Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчид Хаант Орос улсын төлөөлөгчидтэй "Grand hotel"-д хийсэн уулзалтын дараа ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн



1913 он

- Монгол Улсын Ерөнхий сайд, Сайн ноён хан Т.Намнансүрэнгийн хөвгүүн Авидынгэрэл, И.Я.Коростовецын хамт Москва хотын төв талбай дээр ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн



- Монгол Улсын Бүгд ерөнхийлөн захирах сайд, Бүрэн эрх барих Элчин сайд, Сайн ноён хан Т.Намнансүрэнд дурсгасан мөнгөн хайрцаг

Монголын Үндэсний музей



- Монгол Улсын Бүгд ерөнхийлөн захирах сайд, Бүрэн эрх барих Элчин сайд, Сайн ноён хан Т.Намнансүрэнд дурсгасан хоолны хэрэглэл

Монголын Үндэсний музей



1913. 11 дүгээр сар

- Монгол Улсын Ерөнхий сайд, Сайн ноён хан Т.Намнансүрэн тэргүүтэй төлөөлөгчдийг Хаант Орос улсын эзэн хаан Николай II-тай уулзсаны дараа үдэж өгч буй нь

МУУТА. КРЗДАБА



1914 оны намар

- Шинэчлэн зохиосон албаны цахилгаан мэдээний нууц шифр

МУУТА. ТБА. ХА-4, Д-1, ХН-32, Х.1-14



1913.11.17/30/

- Хаант Орос улсын "Огонекъ" сэтгүүлд Сайн ноён хан Т.Намнансүрэн тэргүүтэй Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчдийн айлчлалын тухай нийтэлсэн мэдээ.


"Огонекъ" сэтгүүл. 1913 он. № 46

МОНГОЛЫН ТЭЛЕГРАММА		МОНГОЛЫН ТЭЛЕГРАММА	
№	Тайлбар	№	Тайлбар
1	...	1	...
2	...	2	...
3	...	3	...
4	...	4	...
5	...	5	...
6	...	6	...
7	...	7	...
8	...	8	...
9	...	9	...
10	...	10	...
11	...	11	...
12	...	12	...
13	...	13	...
14	...	14	...
15	...	15	...
16	...	16	...
17	...	17	...
18	...	18	...
19	...	19	...
20	...	20	...
21	...	21	...
22	...	22	...
23	...	23	...
24	...	24	...
25	...	25	...
26	...	26	...
27	...	27	...
28	...	28	...
29	...	29	...
30	...	30	...

1914 он

- Бүгд ерөнхийлөн захирах сайд Сайн ноён хан Т.Намнансүрэн болон яамдын тэргүүн сайдуудад нууц шифрээр илгээсэн цахилгаан утас

МУУТА. ТБА. ХА-6, Д-2, ХН-54, Б.1-4



1915. 08. 30

- Хиагтын гурван улсын гэрээнд оролцохоор томилогдсон Бүгд ерөнхийлөн захирах сайд Т.Намнансүрэн хүндээр өвчилсөн тул оронд нь Дотоод яамны тэргүүн сайд да лам Дашжавыг томилсон тухай бичиг.

МУУТА. ТБА. ХА-3, Д-1, ХН-569, Б.15



1915 он

- Хиагтын 3 улсын гэрээнд гарын үсэг зурах ёслол




- Шадар сайд, Бүгд ерөнхийлөн шийтгэх сайд, Цэргийн яамны тэргүүн сайд, Түмэнхэн номун эзэн, Итгэмжит зетэй, Эрх дайчин Сайн ноён хан Т.Намнансүрэн

МУУТА КТ ЗДАВА

- Монгол Улсын анхны Ерөнхий сайд, Сайн ноён хан Т.Намнансүрэнгийн хэрэглэж байсан тулга. /дөрвөн бадамтай, дөрвөн хөлтэй, Өндөр: 40см, Диаметр: 40см/


Монголын Үндэсний музей



1915.10.13

- Бүгд ерөнхийлөн захирах яамнаас харьяат яамны зэрэг гурван яамдыг хасах ба олон яамны сайд, түшмэдийн орыг хасах, нэмэн тэгшлэн шийтгэж хууль зүйлд оруулан үүрд дагаж явуулах зэрэг учрыг гаргаж гуйн айлтгасан хэрэг

МУУТА, ТБА, ХА-7, Д-1, ХН-281, Б.38



1915.10.15

- Цэргийн яамнаас шинэ тушаалын тэргүүн сайд Сайн ноён хан На тамгыг хүлээн авч Тэнгэрийн хишигт мөргөж, хамт хэрэг шийтгэсэн зэрэг явдлыг айлтгаж, хичээнгүйлэн дагаж зохих олон газар явуулаад, нэгэн адил мэдэгдэн ирсэн хэрэг


МУУТА, ТБА, ХА-7, Д-1, ХН-281, Б.38



1915.10.15

- Цэргийн яамны тэргүүн сайд Халхын Түмэнхэн номун эзэн Сайн ноён хантанаас Тэнгэрийн хишигт мөргөж, Бүгд ерөнхийлөн шийтгэх сайдаар хавсаргасан тушаалын хэргийг хүлээн шийтгэсэн явдлыг айлтгасанд, “Зарлиг мэдэв” хэмээснийг хичээнгүйлэн дагаж, зохих олон газар явуулан тушаагаад мэдэгдэн ирсэн хэрэг


МУУТА, ТБА, ХА-7, Д-1, ХН-281, Б.29



1916.10.19

- Ерөнхийлөн шийтгэх сайдаас айлтгасан айлтгалын хуулга


МУУТА, ТБА, ХА-2, Д-1, ХН-3



1918 он

- Ерөнхийлөн шийтгэх сайдаас олон газраа явуулсан ба тушаасан хуудсын хуулга


МУУТА, ТБА, ХА-2, Д-1, ХН-52



1918 он

• Ерөнхийлөн шийтгэх сайдын данс бичгийн товъёог


МУУТА, ТБА, ХА-2, Д-1, ХН-53



1919.05.16

• Ерөнхийлөн шийтгэх сайдаас олон газраа явуулан тушаасан бичгийн тамганы тоо

МУУТА, ТБА, ХА-2, Д-1, ХН-55



1919.06.26

• Ерөнхийлөн шийтгэх сайдын хувьд цохож гаргасан хуудасны хуулгын данс

МУУТА, ТБА, ХА-2, Д-1, ХН-58



1918 он


- Халхын Түмэнхэн номун эзэн, Итгэмжит эетэй, Эрх дайчин Сайн ноён хан Т.Намнансүрэнд 1913-1918 онд олгосон пүнлүүний данс
МУУТА, ТБА, ХА-6, Д-1, ХН-94. Х.2



1919.04.28

- Цэргийн яамнаас харьяат яамны тэргүүн сайд Түмэнхэн номун эзэн Сайн ноён хан Т.Намнансүрэн өвчний учир нас барсныг мэдэгдэн илгээсэн бичиг

МУУТА, ТБА, ХА-7, Д-1, ХН-518, Б.1



1913.02.25

- Сайн ноён ханы дүү хамба хувилгаан Довчинсодномд зарлигаар хишиг хүртээснийг хичээнгүйлэн дагаж явуулах зэрэг учир тушааж явуулсан эх

МУУТА, ТБА, ХА-9, Д-1, ХН-30. Б.14



- Сайн ноён хан Т.Намнансүрэнгийн эдэлж хэрэглэж байсан ногоон сарьсан эмжээртэй, зулгандаа өнгийн утсаар зүү ороож оёсон, хар булигааран монгол гутал /Өргөн: 30 см, Өндөр: 47 см, Жин: 2630 гр/

Монголын Үндэсний музей



Сайн ноён хан Т.Намнансүрэн хатан Магсаржавын хамт



Хатан Магсаржав



Хүү Авидынгэрэл



Онгийн хүрээний хувилгаан багш Төгс-Очирын Довчинсодном


ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн




1919.12.27

• Сайн ноён хан Т.Намнансүрэнгийн хөвгүүн Батсүхэд Итгэмжит эетэй, Эрх дайчин, Түмэнхэн номун эзэн, Сайн ноён ханы цол хэргэм, шар хүрэм, улбар шар жолоо, ногоон жуузыг үе улиран тасралгүй залгамжлуулсан өргөмжлөл.

Монгол Улсын Үндэсний номын сан



Сайн ноён хан аймгийн ноёд, тайж нарын гэрийн үеийн бичмэл
Монголын Үндэсний номын сан



Халхын Түмэнхэн номун эзэн Сайн ноён ханы
хошууны нутгийн зураг. 1922. 10.18

Монголын Үндэсний номын сан



Халхын Сайн ноён
засгийн тамганы
дардас



Дотоод зэрэг олон
ямны хамаг хэргийг
Бүгд ерөнхийлөн захирах
сайдын тамганы дардас



Монгол Улсын зарлигаар
зарсан Бүрэн эрх барих
Элчин сайдын тамганы
дардас 1913 он